



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬАА
ДУНДГОВЬ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР
АКТ

48090 Дундговь аймаг,
Сайнцагаан сум, Нарлаг баг
Утас: 70-59-24-39, 70-59-22-08, 70-59-32-08
E-mail: dundgovi@audit.gov.mn

САЙНЦАГААН СУМЫН
НЭГДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ М.БОРХҮҮХЭН ТАНАА

2017.02.24 № 01/18 АУА-2017/88 СТА-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-т заасан бүрэн эрхийн хүрээнд аймгийн Аудитын газрын 2017 оны бүтээгдэхүүн, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Сайнцагаан сумын Нэгдүгээр цэцэрлэгийн 2016 оны санхүүгийн тайланд аудит хийх явцад ажилтан албан хаагчдад түлээ нүүрсний хөнгөлөлт олгохдоо нийгмийн даатгалын шимтгэл суутгаж тооцсон дүнгээс хувь хүний орлогын албан татварыг тооцож **30,320.00** /Гучин мянга гурван зуун хорин/ төгрөгийг илүү олгосон зөрчил илэрлээ.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 15 дугаар зүйл шууд бус орлого 15.1.2-т /орон сууцны ашиглалтын зардлын төлбөр, бэлнээр олгосон байрны хөлс, түлшний зардал;/, 22 дугаар зүйлийн 22.1.4.-т /шууд бус орлогод ногдуулах албан татварыг тухайн орлогын дүнгээр;/ 23 дугаар зүйлийн 23.1.-т /Энэ хуулийн 17-19 дүгээр зүйл, 20.1.2-20.1.5, 22.1.4-т зааснаар тодорхойлсон орлогын жилийн дүнд 10 хувиар тооцож албан татвар ногдуулна/ заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1.3-т /Бусдад өгөх төлбөр тооцоог зөрүүтэй тооцоолж олгосон/ заасан заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**


1. Илүү тооцож олгосон **30,320.00** /Гучин мянга гурван зуун хорин/ төгрөгийг холбогдох албан тушаалтнаас суутган тооцож, татварын хэлтсийн **100080000901** тоот дансанд төвлөрүүлэх;

2. Актын биелэлтийг 2017 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор Аудитын газарт ирүүлэхийг Сайнцагаан сумын Нэгдүгээр цэцэрлэгийн эрхлэгч /М.Борхүүхэн/, нягтлан бодогч /Л.Буян-Эрдэнэ/ нарт хариуцуулав.

АКТЫГ

ТОГТООСОН¹:

АУДИТОР  Л.ОЮУН-ЭРДЭНЭ



ЗӨВШӨӨРСӨН:

ЭРХЛЭГЧ  М.БОРХҮҮХЭН

НЯГТЛАН БОДОГЧ  Л.БУЯН-ЭРДЭНЭ



¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.